



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир,
спортын холбооны төлөөлөгчдийг
хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Биеийн тамир, спортын газар болон БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир, спортын холбооны хооронд биеийн тамир, спортын харилцан хамтын ажиллагааг эрчимжүүлэх, харилцан зөвшилцлөөр дамжуулан эгч дүүгийн харилцаа холбоо тогтоох чиглэлээр санамж бичиг байгуулах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо ажлын айлчлал хийх БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир, спортын холбооны ерөнхийлөгч Жион Гапсу тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулсугай.

2. Төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардал 1,450,000 (нэг сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийг Үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргахыг нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг өндөр түвшинд зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны 06 сарын 03-ны
өдрийн 144 дугаар тушаалын хавсралт



БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир,
спортын холбооны төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг
зохион байгуулахад шаардагдах төсөв

№	Зардлын нэр, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1.	Орчуулагчийн зардал (1 хүн х 3 өдөр)	150,000	450,000
2.	Бэлэг дурсгалд (8 хүн)	100,000	800,000
3.	Санамж бичиг зурахад шаардагдах цай, кофе, ус, ундааны зардал	200,000	200,000
Нийт дүн			1,450,000